

Хоёрдугаар бүлэг

ОХ-ны зорилго

2.1 ОХ-ны эрхэм зорилго нь Сэрүүлэг Дээд Сургуулийн нийт оюутан суралцагчдыг төлөөлөн удирдах олон нийтийн байгууллага байж тэдгээрийн хууль ёсны бөгөөд нийтлэг эрх ашиг, сонирхолыг Монгол улсын болон олон улсын хэмжээнд төлөөлөн хамгаалах, түүний бие даан хөгжих бололцоог хангах, бүтээлч хамт олныг төлөвшүүлэх, оюутнуудын нийгмийн идэвхийг дээшлүүлэх, төрөөс оюутнуудын талаар явуулж байгаа бодлого гаргах шийдвэрт нөлөөлөх түүнийг хэрэгжүүлэхэд оршино...

Гуравдугаар бүлэг

“Сэрүүлэг Дээд Сургуулийн “Оюутны холбооны бодлого үйл ажиллагаандаа дараах үнлсэн чиглэл баримтлана.

3.1 Оюутны холбоо нь үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг удирдлага болгож оюутнуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж, нас, бие, сэтгэхүйн онцлогийг харгалзан ажилна.

3.2 Оюутнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор сургалт семинар хэлэлцүүлэг, зохион байгуулах, холбогдох материалаар хангах, тэдэнд чөлөөт цагийг нь үр дүнтэй зүйлд зарцуулахад нь туслах.

3.3 Оюутанд тулгамдсан бүхий л асуудлаар судалгаа шинжилгээ хийж, оюутан, сургууль хоорондын харилцан мэдээлэл санал бодол солилцох бүх талын бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах.

3.4 Төрөөс оюутнуудын талаар баримтлах бодлого шийдвэрийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай оролцох, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих.

3.5 Монголын оюутны хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалан хөгжүүлэх, оюутны байгууллагын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх мэдээлэл санал бодлоо чөлөөтэй солилцох илэрхийлэх бололцоог бүрдүүлэх.

3.6 Оюутны байгууллага, сургуулийн удирдлагын хооронд нь холбож оюутны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.

3.7 Оюутны дунд илтгэл, эрдэм шинжилгээ, урлаг спорт, соёлын олон төрөлт арга хэмжээг зохион байгуулах, нэгж оюутаны бие дааж хөгжих нөхцлийг бүрдүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх шинэлэг ажлыг үүсгэн хөгжүүлэх, оюутны нийтлэг эрх ашгийг төлөөлөн илэрхийлж хамгаалах.

3.8 “ОХ”-ны үйл ажиллагаандаа баримтлах зарчим.

3.8.1 Удирдах удирдуулах ёс.

3.8.2 Үйл ажиллагаандаа ардчиллын зарчмыг баримтлах.

3.8.3 Оюутнуудын эрх ашгийн төлөө үйлчлэх

3.8.4 Зохион байгуултын хувьд нэгдмэл тогтвортой залгамж чанартай байх.

Дөрөвдүгээр бүлэг

Сэрүүлэг Дээд Сургуулийн Оюутны холбооны бүтэц зохион байгуулалт

4.1 Оюутны холбооны гишүүнчлэл.

4.2 Оюутны холбооны эрх барих дээд байгууллага нь чуулган байна.

4.3 Удирдах зөвлөл.

4.4 Хяналтын зөвлөл.

4.5 Гүйцэтгэх алба.

4.1.1 “Сэрүүлэг дээд сургуулийн” нийт оюутан суралцагч нар “ОХ”-ны гишүүн байна.

4.1.2 Оюутны холбооны үйл ажиллагаанд онцгой хувь нэмэр оруулсан байгууллага , хувь хүмүүсийг Оюутны холбооны хүндэт гишүүнээр бүртгэж, өргөмжлөл олгож болно.

4.1.3 Гишүүн дараах эрх , үүрэгтэй байна.

4.1.3.1 Оюутны холбооны удирдлаганд сонгогдох, сонгох.

4.1.3.2 Оюутны холбооны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах.

4.1.3.3 Оюутны холбооны үйл ажиллагаатай холбогдуулж байр сууриа чөлөөтэй илэрхийлэх.

4.1.3.4 Оюутны холбооноос зохион байгуулж буй арга хэмжээ, шйл ажиллагаанд идэвхитэй оролцох.

4.1.3.5 Оюутны холбооны харъяа бүлэг байгуулах харъяалагдах.

4.2 Чуулган нь дараах эрх үүргийг эдэлнэ.

4.2.1 Оюутны холбооны үйл ажиллагааны ойрийн болон хэтийн зорилтыг тодорхойлох.

4.2.2 СДС/ОХ-ны тэргүүн, дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга, хяналтын зөвлөлийг сонгох, чөлөөлөх.

4.2.3 Удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэх.

4.2.4 Дүрмийг шинэчлэх батлах , нэмэлт өөрчлөлт оруулах.

4.2.5 Оюутны холбооны үндсэн чиг баримтлал , хөтөлбөрийг батлах.

4.2.6 Оюутны холбоог татан буулгах, өөрчлөх.

4.2.7 Чуулган нь Оюутны холбооны гишүүдээс бүрдэнэ. Чуулганы төлөөлөгчид сонгох журмыг удирдах зөвлөлийн хурлаар тогтооно.

4.2.8 Чуулганы товыг оюутны холбооны тэргүүн тогтоож 14 хоногийн өмнө УЗ-Д хэлэлцэх асуудал , чуулганы дэг зэргийг гаргаж чуулганы бэлтгэл үйл ажиллагаанд орох үүргийг гүйцэтгэх албанд өгнө.

4.2.9 Чуулган нь 2 жилд 1 удаа хуралдах бөгөөд ээлжит бус чуулганы удирдах зөвлөлийн гишүүдийн 50% иас доошгүй саналаар оюутны холбооны ээлжит бус хурлыг хуралдуулж болно .

4.2.10 Чуулганыг таслах эрхтэй төлөөлөгчдийн 51% нь оролцсон тохиолдолд хүчинтэй тооцно.

4.2.11 Чуулганыг удирдах зөвлөлийн тэргүүн удирдан явуулна.

4.2.12 Чуулганаар ярилцсан асуудал батлагдсанаар хүчин төгөлдөр болно.

Удирдах зөвлөл, тууний эрх үүрэг хэмжээ

4.3 Удирдах зөвлөл нь чуулган эрхээс бусад үед эрхийг эдлэж оюутны холбооны шийдвэр гаргах дээд байгууллага нь удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.3.1 Оюутны холбооны жилийн төсөв , төлөвлөгөөг батлах.

4.3.2 Оюутны холбооны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар эрх хэмжээг тогтоох .

4.3.3 Оюутны холбооны гүйцэтгэх албаны бүтэц , зохион байгуулалт, түүний төсвийг батлах.

4.3.4 Удирдах зөвлөлийн хурал нт гишүүдийн 2/3 ирснээр хүчинтэй тооцож шийдвэр гаргана.

4.3.5 Ээлжит бус чуулган зарлах тухай санал гаргах

4.3.6 Удирдах зөвлөл нь ОХ- ны тэргүүний санал болгосны дагуу шаардлагатай гэж үзсэн асуудлаар бодлого төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилго бүхий хороо зөвлөлийг байгуулан ажиллаж болно.

4.3.7 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн тэргүүн, дэд тэргүүн, нарийн бичгийн дарга, нараас бүрэлдсэн 3 гишүүнтэй байна.

4.3.8 Удирдах зөвлөлийн хурал нь чуулганы чөлөөт цагт холбооны үйл ажиллагааны тасралтгүй чанарыг хангаж удирдлага зохион байгуулалтаар хангана.

4.3.9 Удирдах зөвлөлийн дарга нь сэрүүлэг дээд сургуулийн ОХ –ны тэргүүн байна.

4.3.10 Удирдах зөвлөлийн хурлын тэргүүн, дэд тэргүүн болон нарийн бичгийн дарга ахлах хурал

4.4 Хяналтын зөвлөл

4.4.1 Хяналтын зөвлөл нь 3-н гишүүнээс бүрдэнэ,

4.4.2 Хяналтыгн зөвлөлийн гишүүдийн чуулганаас нэр дэвшүүлэн ил санал хураалтаар сонгонго. Хяналтын дарг,ыг хяналтын зөвлөлийн гишүүд илээр санал хурааж сонгоно. П

4.4.3 хяналтын зөвлөлийн гишүүд сард нэг удаа хуралдаж, удирдах зөвлөлд мэдээлэл хийж үйл ажиллагаанд хяналт тавьж байна.

4.4.4 Хяналтийн зөвлөлийн гишүүд нь дүрмийн хэрэгжилт, удирдлага, санхүлжилт, гишүүнчлэлийн асуудал хяналт хийх эрхтэй ба ажлаа чуулганд тайлагнаж, удирдах зөвлөл мэдээлэж шийдвэрлүүлж байна.

4.4.5 Хяналтын зөвлөлийн гишүүн СДС / ОХ-ны ямар нэгэн албан тушаалд ажиллахгүй ба түүнд тавигдах шаардлага нь удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагатай байна.

4.5 Гүйцэтгэх алба

4.5.1 ОХ –ны хурал хоорондын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх алба гүйцэтгэнэ.

4.5.2 Гүйцэтгэх алба нь ОХ – ны дэд тэргүүн ахласан 6 – н гишүүдээс бүрдэнэ.

4.5.3 Гүйцэтгэх албаны гишүүдыг ОХ-ны тэргүүн санал оруулж , төлөөлөгчдийг олонхийн саналаар сонгоно.

4.5.4 Гүйцэтгэх алба 14 хоногт 1-с доошгүй хуралдана.

4.5.5 Хуралдааныг гишүүдийн 2/3 нь ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.5.6 Гүйцэтгэх албаны төлөвлөгөөг батлах , гишүүний татварын хэмжээг тогтоох асуудлыг анги группийн ахлагч нарыг хуралдаанаар шийдвэрлэнэ.

Тавдугаар бүлэг

Тэргүүн , Дэд тэргүүн ,Ерөнхий нарийн бичгийн эрх үүрэг.

Тэргүүн түүний эрх үүрэг

5.1 СДС/ОХ – ны тэргүүнийг чуулганаас нэр дэвшүүлэн нууцаар болон илээр санал хураалт явуулж сонгоно.

5.2 Тэргүүний бүрэн эрхийн хугацаа дараагийн чуулган хүртэл үргэлжилнэ. Энэ хугацаанд салбар хороодын болон клубуудын хурал зөвлөгөөнд оролцох тэргүүлэх эрхтэй.

5.3 СДС/ОХ-ны тэргүүн монгол улсын иргэн ОХ-ны нэр төрийг монгол улсын болон олон улсын хэмжээнд өндөрт өргөж чадах тус сургуулийн оюутан байх оюутны холбооны албан ёсны төлөөлөгч, сэрүүлэг дээд сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлийн /ТУЗ/-н гишүүн байх бөгөөд төр засгийн болон олон нийтийн байгууллагуудтай холбоо тогтоох ба хамтран ажиллах ажлыг хариуцна.

5.3.Сэрүүлэг дээд сургуулийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-с гарах шийдвэрт оюутны дуу хоолойг хүргэх түүнд нөлөөлж нийт оюутны массыг хамарсан шийдвэр гаргуулах.

5.4 Тэргүүн сэрүүлэг дээд сургуулийн ТУЗ-д хөндөгдсөн асуудлаар,гарсан шийдвэрт бие даан шийдвэр гаргах эрхтэй ба шийдвэрийг ОХ-ны удирдах зөвлөл хуралдаж асуудлыг авч хэлэлцэнэ.

5.5 Тэргүүн нь ОХ-г төлөөлөх ОХ-ны удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах ба удирдах зөвлөлийн чуулганаар хэлэлцэх асуудлыг шалган батлаж оюутны холбооны жилийн тайланг чуулганд тавина.Удирдах зөвлөл ,чуулганаас гаргасан шийдвэрийг үндэслэн холбогдох хүмүүст үүрэг өгөх эрхтэй.

5.6 Тэргүүн нь ОХ-г удирдах зөвлөлд удирдах зөвлөлийн гишүүний талаар эхний удаа санал оруулж шийдвэрлүүлэх ба дараагийн удаа шууд чөлөөлнө.

А.Оюутны холбооны албан ёсны үйл ажиллагаанд хүндэтгэх шалтгаангүйгээр 3 удаа оролцоогүй бол.

Б.Эрх зүйн болон ёс зүйн алдаа гаргасан бол.

В. Өөрийн үүрэгт ажлаа 3 удаа хангалтгүй.

5.7 Тэргүүн нь сонгогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор ерөнхий нарийн бичгийн даргийг удирдах зөвлөлд санал оруулах ба 1 хүнийг 1 удаа , дахин дэвшүүлж болно.

5.8 Дэд тэргүүн түүний эрх үүрэг.

5.8.1 Оюутны холбооны тэргүүн бүрэн эрхийнхээ хугацаагаас өмнө эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан, хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөлд дэд тэргүүн шинэ тэргүүн сонгогдтол тэргүүний үүргийг гүйцэтгэнэ.

5.8.2 Оюутны холбооны гадаад дотоодын хамтын ажиллагааг хариуцах ба "Сэрүүлэг дээд сургууль"-ийн оюутны зөвлөлийг ахалж ажиллана.

5.8.3 Оюутны холбооны дотоодын мэдээлэл, харилцааны асуудлыг зохицуулна.

5.8.4 Оюутны холбооны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх ажлын аппарат гүйцэтгэх албыг удирдаж ажиллуулна.

5.8.5 Оюутны холбооны санхүү , тайлан балансыг хариуцаж ажиллана.

5.8.6 Цаг үе тулгамдсан асуудлаар тодорхой байр суурь баримтлан ажиллаж , бусад байгууллагуудад оюутны холбооны төлөөлөл болон ажиллана.

5.8.7 Гүйцэтгэх албаны гишүүдийг томилох ,чөлөөлөх саналыг анги , группийн ахлагч нарын хурал, удирдах зөвлөл, чуулганд оруулах.

5.8.8 Гүйцэтгэх албаны хурлуудыг товлон хуралдуулж, үйл ажиллагааг удирдана.

5.9 Ерөнхий нарийн бичгийн даргын эрх үүрэг хариуцана.

5.9.1 Ерөнхий нарийн бичгийн дарга нь ОХ-ны нийслэлийн нийтийн тээвэртэй холбоотой болон ОХ-ны удирдах зөвлөлөөс гарсан тогтоол шийдвэрийг шууд дагаж мөрдөж ажиллана.

5.9.2 Ерөнхий нарийн бичгийн дарга нь оюутны байгууллага болон олон нийтийн ажилд идэвх зүтгэлтэй оролцож байсан, шаардлага хангахуйц оюутан байна.

5.9.3 Ерөнхий нарийн бичгийн даргын гүйцэтгэх ажиллын чиг үүрэг , эрх хэмжээг удирдах зөвлөлөөс тогтоох ба хариуцлагыг тогтолцоо нь удирдах зөвлөлийн гишүүний адил үйлчилнэ.